



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 1/38

Мандалговь

Шагнах тухай

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, аймгийн Засаг даргын 2013 оны 565 дугаар захирамжаар батлагдсан “Шагналын жишиг тогтоох тухай журам”-ын 2 дугаар бүлгийн 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хулд сумын уугуул Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан Нямбуугийн Баянмөнх Монголын яруу найргийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж, Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” хүртсэн тул аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнасугай.

Хоёр. Мөнгөн шагналд 250000 /хоёр зуун тавин мянга/, хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 /гучин таван мянга/, хадаг 5000 /таван мянга/, нийт 290000 /Хоёр зуун ерэн мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000078